

ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ЦАГААН-ОВОО СУМЫН ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН,  
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

**Аудитын код:** ДОА-2022/11/НА/СТА-ТТЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Чойбалсан хот 2022 он</p>	<p>Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn Аудитын менежер: И.Сэмжидмаа Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Нармандах Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

---

1. Аудитын санал дүгнэлт .....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	3
3. Аудитын тайлан .....	7
3.1 Ерөнхий зүйл .....	7
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	7
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	8
3.4 Материаллаг байдал .....	8
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	8
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	8
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	9
3.8 Аудитын гол асуудал .....	9
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	10
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	10
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	10
4. Аудитын илрүүлэлт .....	10
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	11

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аудитын газар
НА	Нотлох аудит
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СХС	Сум хөгжүүлэх сан
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч

## 1.Хараат бус аудиторын дүгнэлт



Г ЦАГААН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГА 1  
Д.БАТМАГНАЙ ТАНАА

**ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг  
З/ДТ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2022.05.25 № 392

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г 1

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Цагаан-Овоо сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цагаан-Овоо сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.БОЛОРТУУЛ

  
011020213

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>878,969.0</b>	<b>1,277,790.8</b>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	286,390.1	608,907.0
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	286,390.1	608,907.0
31210	Төгрөг	286,390.1	608,907.0
33	АВЛАГА	256,690.1	292,362.2
35	БАРАА МАТЕРИАЛ	335,888.7	376,521.6
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>6,246,961.1</b>	<b>6,280,587.5</b>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,246,961.1	6,280,587.5
39200	Биет хөрөнгө	6,037,910.5	6,001,713.1
39300	Биет бус хөрөнгө	209,050.6	278,874.4
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>7,125,930.1</b>	<b>7,558,378.3</b>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	7,739.1	0.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	7,739.1	0.0
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>7,118,191.0</b>	<b>7,558,378.3</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>7,118,191.0</b>	<b>7,558,378.3</b>
5110	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3,949,442.4	3,949,442.4
<b>5120</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>753,819.6</b>	<b>1,194,007.0</b>
5130	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,414,928.9	2,414,928.9
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>7,125,930.1</b>	<b>7,558,378.3</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>4,796,836.8</b>	<b>4,239,487.5</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>118,897.9</b>	<b>261,813.8</b>
110	Орлогын албан татвар	99,699.4	118,747.0
1100	Хувь хүний орлогын албан татвар	99,699.4	118,747.8
113	Хөрөнгийн албан татвар	1,440.0	78,867.4
118	Бусад татвар, төлбөр, хураамж	17,758.5	64,198.5
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,283,806.2</b>	<b>986,227.9</b>
120	Нийтлэг татварын бус орлого	1,073,806.2	761,227.9
122	Тусламжийн орлого	210,000.0	225,000.0
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>3,394,132.8</b>	<b>2,991,445.8</b>
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>3,835,035.4</b>	<b>3,484,411.6</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,835,035.4</b>	<b>3,484,411.6</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,972,797.7</b>	<b>3,424,854.0</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,612,261.2	1,844,010.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	196,241.6	239,131.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	152,212.4	159,564.8
2104	Хангамж, бараа материалын зардал	148,018.5	172,978.1
2105	Нормативт зардал	130,888.1	405,675.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,180.0	37,354.9
2107	Томилолт, зочны зардал	10,105.0	4,669.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23,188.0	4,551.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	686,702.8	556,917.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>862,237.7</b>	<b>59,557.7</b>
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>961,801.4</b>	<b>755,075.9</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>299,339.0</b>	<b>314,888.5</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>662,462.4</b>	<b>440,187.3</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>3,949,442.4</b>	<b>2,414,946.6</b>	<b>91,339.5</b>	<b>6,455,728.6</b>
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.0	0.0	17.7	17.7
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,949,442.4	2,414,946.6	91,357.3	6,455,746.3
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	-17.7	0.0	-17.7
9	Тайлант үеийн үр дүн	0.0	0.0	662,462.4	662,462.4
10	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>3,949,442.4</b>	<b>2,414,928.9</b>	<b>753,819.6</b>	<b>7,118,191.0</b>
11	<b>2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>3,949,442.4</b>	<b>2,414,928.9</b>	<b>753,819.6</b>	<b>7,118,191.0</b>
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,949,442.4	2,414,928.9	753,819.7	7,118,191.0
19	Тайлант үеийн үр дүн	0.0	0.0	440,187.3	440,187.3
20	<b>2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл</b>	<b>3,949,442.4</b>	<b>2,414,928.9</b>	<b>1,194,007.0</b>	<b>7,558,378.3</b>

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>3,951,019.2</b>	<b>3,529,532.9</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>118,897.9</b>	<b>261,813.8</b>
110	Орлогын албан татвар	99,699.4	118,747.8
1100	Хувь хүний орлогын албан татвар	99,699.4	118,747.8
113	Хөрөнгийн албан татвар	1,440.0	78,867.4
118	Бусад татвар, төлбөр, хураамж	17,758.5	64,198.5
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	3,609.9	6,264.1
1181	Газрын төлбөр	7,124.1	54,570.9
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	7,024.5	3,363.4
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>437,988.5</b>	<b>399,457.3</b>
120	Нийтлэг татварын бус орлого	80,543.8	174,457.3
122	Тусламжийн орлого	357,444.7	225,000.0
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>3,394,132.8</b>	<b>2,868,261.8</b>
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>3,285,639.4</b>	<b>2,857,496.9</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,285,639.4</b>	<b>2,857,496.9</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,423,241.0</b>	<b>2,798,099.8</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,611,642.2	1,843,547.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	196,851.1	239,598.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	145,290.4	157,485.1
2104	Хангамж, бараа материалын зардал	82,421.0	127,193.3
2105	Нормативт зардал	118,278.4	187,766.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,604.0	86,549.3
2107	Томилолт, зочны зардал	10,105.0	4,669.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,	23,488.0	4,551.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	221,560.8	146,739.1
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>862,398.4</b>	<b>59,397.0</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	18,764.1	45,864.9
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>665,379.8</b>	<b>672,036.0</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>432,691.4</b>	<b>331,519.1</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>432,691.4</b>	<b>331,519.1</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	432,691.4	331,519.1
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН</b>	<b>-432,691.4</b>	<b>-331,519.1</b>
<b>VII</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР</b>	<b>-32,000.0</b>	<b>-18,000.0</b>
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР</b>	<b>32,000.0</b>	<b>18,000.0</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>200,688.4</b>	<b>322,516.9</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	85,701.7	286,390.1
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	286,390.1	608,907.0

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>3,302,485.3</b>	<b>2,800,319.2</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,625,216.1</b>	<b>2,467,430.7</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,594,757.2</b>	<b>2,437,867.9</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,792,343.0	1,703,771.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	230,878.2	221,689.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	164,211.6	155,119.3
2104	Хангамж, бараа материалын зардал	97,747.6	96,110.5
2105	Нормативт зардал	118,710.0	108,544.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	74,934.0	74,914.9
2107	Томилолт, зочны зардал	13,311.7	2,985.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,187.8	4,606.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	95,433.3	70,125.7
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>30,458.9</b>	<b>29,562.8</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	30,458.9	29,562.8
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>629,469.2</b>	<b>314,888.5</b>
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>47,800.0</b>	<b>18,000.0</b>
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>3,302,485.3</b>	<b>3,058,925.5</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,689,151.9</b>	<b>1,675,619.7</b>
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,049,931.8</b>	<b>946,909.7</b>
<b>33</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>35,704.3</b>	<b>18,838.1</b>
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>302,697.3</b>	<b>192,557.9</b>
<b>36</b>	<b>ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ</b>	<b>225,000.0</b>	<b>225,000.0</b>

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>354,703.1</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>354,703.1</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>338,401.0</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	121,800.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,652.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,365.8
2104	Хангамж, бараа материалын зардал	24,830.8
2105	Нормативт зардал	79,222.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	28,210.0
2107	Томилолт, зочны зардал	1,684.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	64,636.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>16,302.1</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,302.1
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>354,703.1</b>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	354,703.1

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Цагаан-Овоо сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Нармандах гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер И.Сэмжидмаа, газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Болортуул нар тус тус хэрэгжүүлсэн.

Цагаан-Овоо сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 3 дугаар сарын 01-ний өдрийн 1/64 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл нь харьяалах нутаг дэвсгэрийнх нь эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудлаар төрийн эрх бүхий байгууллагаас батлах төсөл, хөтөлбөрт санал өгөх, тэдгээрийн хэрэгжилтийг зохион байгуулах, нутгийн захиргааны байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангах, иргэдэд төрийн үйлчилгээг хүргэх.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллага нь хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын нэгжгүй бөгөөд хяналтыг аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү, хяналт аудитын алба, Санхүү, төрийн сангийн хэлтэс хэрэгжүүлэн ажилладаг байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү, хяналт аудитын алба нь 2021 онд Орон нутгийн хөрөнгө оруулалт болон ОНХС, СХС-гийн 2020-2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийсэн байна.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цагаан-Овоо сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төлөвлөгөөний нийт зардлын 3,484.4 сая төгрөгөөс 1 хувиар тооцон 34.8 сая төгрөгөөр гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 24.4 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 608.9 сая төгрөг болж өмнөх оноос 322.5 сая төгрөгөөр өссөн байна.

Авлага дансны үлдэгдэл 292.4 сая төгрөг болж өмнөх оноос 35.7 сая төгрөгөөр өссөн нь эрүүл мэндийн даатгалын санхүүжилт дутуу олгогдсонтой холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 376.5 сая төгрөг болж 40.6 сая төгрөгөөр өссөн нь эмнэлгийн эм боох материал нөөцөлсөн, “Эх хэл эрдмийн түлхүүр тэтгэлэгт хөтөлбөр”-ийн хүрээнд сургалтын хэрэглэгдэхүүн худалдан авсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 6,280.6 сая төгрөг болж 33.6 сая төгрөгөөр өссөн нь ковидын санхүүжилт болон бусад эх үүсвэрээр эмнэлэгт тоног төхөөрөмж нэмэгдсэнтэй холбоотой байна.

Биет бус хөрөнгийн дансны үлдэгдэл 278.9 сая төгрөг байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 7,558.4 сая төгрөг болж 440.2 сая төгрөгөөр өссөн нь орон нутгийн болон орон нутгийн хөгжүүлэх сангийн хөрөнгө оруулалт хийгдсэнтэй холбоотой байна.

Цагаан-Овоо сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 557.3 сая төгрөгөөр буюу 11.6 хувиар буурсан байна.

Нийт зардал өмнөх оноос 350.6 сая төгрөгөөр буюу 9.1 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа үйлчилгээний бусад болон үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Цагаан-Овоо сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 3,302.5 сая төгрөгөөр, нийт зарлагыг 3,302.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 3,302.5 сая төгрөгийн төсөв баталснаас орон нутгийн төсвөөс 1,049.9 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээс 1,689.2 сая төгрөг, нийгмийн даатгалын сангийн төсвөөс 35.7 сая төгрөг, үйл ажиллагааны орлогоос 302.7 сая төгрөг, хандив тусламжийн орлогоос 225.0 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1,026.9 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээс 1,675.6 сая төгрөг, нийгмийн даатгалын сангийн төсвөөс 18.8 сая төгрөг, үйл ажиллагааны орлогоос 112.6 сая төгрөг, хандив тусламжаас 225.0 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр орлого бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,800.3 сая төгрөг буюу 91.5 хувийн гүйцэтгэлтэй байна.

Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуульд зааснаар 2021 онд 244.4 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 262.1 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 107.2 хувиар биелүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 330.6 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 5.0 сая, хандив тусламжийн 19.1 сая, нийт 354.7 төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлд 137.5 сая, байр ашиглах зардалд 2.4 сая, хангамж, бараа материалын зардалд 24.8 сая, норматив зардалд 79.2 сая, эд хогшил, урсгал засварын зардалд 28.2 сая, дотоод албан томилолт 1.7 сая төгрөг, бусад зардалд 64.6 сая, тэтгэмжийн зардалд 16.3 сая төгрөг, нийт 354.7 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Засаг даргын Тамгын газар нь Бараа материалын дансанд бүртгэлтэй малын тооллого хийсэн бүртгэл, тайлан байхгүй, зөвхөн А дансыг үндэслэн бүртгэл тайланд тусгасан байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Засаг даргын Тамгын газар нь бараа материалын дансанд бүртгэлтэй 31.5 сая төгрөгийн аж ахуйн материалд тооллого хийгээгүй санхүүгийн тайлан бэлтгэсэнд “Хязгаарлалттай санал дүгнэлт” хүргүүлсэн.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант хугацаанд оруулбал зохих 154 мэдээллээс 2 мэдээлэл хугацаа хоцроон мэдээлсэнд Шилэн дансны тухай хуульд заасан хугацаанд мэдээллийг байршуулж байх зөвлөмж өгсөн.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

#### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 274.6 сая төгрөгийн 3 албан шаардлага, 1 зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна.

#### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц чухал асуудал гараагүй.

### **4. Аудитын илрүүлэлт**

---

Аудитаар нийт 259.3 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлсэн.

#### **4.1 Залруулсан алдаа**

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай залруулах бичилт хийгдээгүй болно.

#### **4.2. Албан шаардлага**

1. Санхүүгийн тайланд тусгагдсан авлагын 20.6 хувь нь СХС-гаас олгосон зээл, зээлийн хүүгийн 60.5 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн авлага байна. Үүнээс 51.6 сая төгрөгийн авлага нь шүүхийн шийдвэртэй, 8.9 сая төгрөгийг барагдуулах зохион байгуулалтын ажил хийгдээгүй байна. Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах,

тайлагнах, хяналт тавих, журам"-ын 4.7 -д "Иргэн, хуулийн этгээд авсан зээл, зээлийн хүүг гэрээнд заасан хугацаанд сангийн дансанд буцаан төлнө", 5.2-т "Сангийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг сумын Засаг дарга хариуцан арилгана" гэсэн заалттай нийцэхгүй байна.

2.Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 530.9 сая төгрөгийн 25 төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээр батлагдсан байна. Үүнээс "Нийтийн эзэмшлийн талбайн засвар арчилгаа" 13.2 сая төгрөгийн ажил 45.6 хувийн, "Шинэ усан сан төсөл" 60.0 сая төгрөгийн ажил 50 хувийн гүйцэтгэлтэй, "Багийн Иргэдэд үйлчлэх төв шинээр барих" 53.0 сая төгрөгийн, "Наадмын талбайн тохижилт" 5.0 сая төгрөгийн, "зураг төсөв хийлгэх ажил" 30.0 сая төгрөгийн, "Хоёрдогч түүхий эд авах цэг байгуулах, нийтийн эзэмшлийн хог хаягдал цэвэрлэх" 20.0 сая төгрөгийн, "Гудамжны камержуулалт" 20.7 сая төгрөгийн, "Хогны сав байршуулах" 9.9 сая төгрөгийн, "Эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмж /ковидоос урьдчилан сэргийлэх/" 22.5 сая төгрөгийн 7 төсөл арга хэмжээ огт хийгдээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2-т "Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ", 41.2.7-д "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах" гэсэн заалттай нийцэхгүй байна

Дээрх шилэн дансны тухай хуульд заасан хугацаанд мэдээллийг байршуулж байх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	<b>Цагаан-Овоо сумын ТТЗ</b>	3	259.3	-	-	-	-	2	259.3	1	-

/сая төгрөгөөр/